



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/01

Бэрх хот

Олон нийтийн
эргүүл хийх тухай

Монгол улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дүгээр зүйлийн 25.1 дэх заалт, "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчдыг олон нийтийн эргүүлд гаргаж ажиллах хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хуваарийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн эргүүлийн ажилд Батноров сумын сум дундын Цагдаагийн тасагтай хамтарч үр дүнтэй, хариуцлагатай ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хотын захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн A/01 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАГЧИЙН  Ч.ЭНХЖАВХЛАН

232601008